

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**
(2022 оны эхний хагас жилийн байдлаар)

2022.06.27

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлогын 5 тэргүүлэх зорилтод хамаарах нийт 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 36 хавсралт (ЗГ-ын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)-д заасан загвар хүснэгтээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнав.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг хавсралт – 1, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг хавсралт 2-оор тайлагнав.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

Бодлого, арга хэмжээгээр харуулбал:

- Эдийн засгийн бодлогын 2 зорилтын 3 арга хэмжээний дундаж 36.7 хувь;
- Засаглалын бодлогын 3 зорилтын 9 арга хэмжээний дундаж 75.5 хувь.

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 2022 оны эхний хагас жилийн байдлаар – **63.3% буюу “Эрчимжүүлэх шаардлагатай”** байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Бодлого		
			Эдийн засаг	Засаглал	
1	Хяналтад авсан зорилтын тоо	5	2	3	
2	Хяналтад авсан арга хэмжээний тоо	12	3	9	
3	Үнэлгээний хувь	100.0 хувь	-	-	
4		90.0 хувь	-	2	
5		70.0 хувь	6	-	6
6		50.0 хувь	2	1	1
7		30.0 хувь	2	2	-
8		0.0 хувь	-	-	-
9	Хэрэгжилтийн хувь	63.3 хувь	36.7 хувь	75.5 хувь	


Үндсэн хэрэгжүүлэх нэгжээр нь харуулбал:

- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 2 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 54.0 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 80.0 хувь;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 70.0 хувь;
- Хууль, эрх зүйн хэлтэс 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 63.3 хувьтай байна.

д/д	Хэрэгжилт	Бүгд	Хэлтэс			
			ТӨҮЗХэлтэс	ТӨБАХэлтэс /МТА, ЗУХ/	ТӨХШХэлтэс	ХЭЗХэлтэс /ТӨҮЗХ/
1	Хяналтад авсан арга хэмжээний тоо	12	5	2	2	3
2	Үнэлгээний хувь	100.0 хувь	-	-	-	-
3		90.0 хувь	2	1	1	-
4		70.0 хувь	6	1	1	2
5		50.0 хувь	2	1	-	1
6		30.0 хувь	2	2	-	-
7		0.0 хувь	-	-	-	-
8	Хэрэгжилтийн хувь	63.3 хувь	54.0 хувь	80.0 хувь	70.0 хувь	63.3 хувь

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021 он, 2022 оны эхний хагас жилийн байдлаар харуулбал:

Хэрэгжилт



■ 2021 оны эхний хагас жил ■ 2021 оны жилийн эцэс ■ 2022 оны эхний хагас жил

2022 оны төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрээгүй, цаашид зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай 30-50 хувийн хэрэгжилттэй дараах арга хэмжээнүүд байна.

- 3.2.7.5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийнэ. 50%
Үр дүн: Зэсийн баяжмалыг хайлуулах, боловсруулах явцад гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг боловсруулж, элементийн хүхэр үйлдвэрлэх туршилт, судалгааны ажил хийгдэж байгаа. Туршилтын ажлын санхүүжилтийн 90% буюу 10,115.0 сая төгрөг шилжүүлсэн. China ENFI компани туршилтын үйлдвэр барьж байгуулах бүх шаардлагатай зөвшөөрлийг орон нутгаас авсан, барилга угсралт, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн захиалга эхэлсэн. **Хэрэгжилт -30.0 хувь;**
- 3.2.7.6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусгана. 100%
Үр дүн: Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX-EW) технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр /Катодын зэсийн үйлдвэр/-ийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил гэрээний дагуу гүйцэтгэгч компани 2022 оны 8 дугаар сард хүлээлгэж өгнө Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX/EW технологитой катодын зэсийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлнэ. барилгын ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлнэ. **Хэрэгжилт -30.0 хувь;**
- 3.7.8.1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Үндэсний орон сууцны нэгдсэн корпорацийг шинээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.
Үр дүн: Холбогдох судалгааг хийж, Ерөнхий сайд, ЗГХЭГазар, БХБЯамны сайдуудад танилцуулан, зөвшилцөж, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан. Шийдвэрийн дагуу ТӨБЗГазраас холбогдох зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргах шийдвэр хүлээгдэж байна. **Хэрэгжилт 50.0%;**
- 4.4.10.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын асуудлаар 3 журмын төслийг баталж, мөрдүүлсэн байна.
Үр дүн: "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам", гэрээний загварыг баталж мөрдүүлээд байна. **Хэрэгжилт: 50.0%.**

Тайлант хугацаанд тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хамаарах шийдвэрийг гаргаж, дээд шатны байгууллагуудаас болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас хамаарч 70.0 хувиар үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна.

- 4.2.4.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Төрийн болон орон нутгийн өмчийн асуудлыг хариуцсан тохируулагч агентлаг бий болсон байна.

- Үр дүн:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Засгийн газрын хуралдаанд 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр хэрэлцэгдэж, зарчмын зөрүүтэй асуудлыг цэгцлэх зорилгоор буцаагдсан. **Хэрэгжилт 70.0%;**
- 4.4.10.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Хуулийн төслийг батлуулсан байна.
Үр дүн: УИХ-ын 06 дугаар сарын 09-10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэх тухай асуудлыг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн. **Хэрэгжилт 70.0%;**
 - 4.4.10.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ.
2022 оны зорилтот түвшин, үр дүн: Компанийн засаглалын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн байна.
Үр дүн: Компанийн засаглалын олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх хүрээнд Төрийн өмчит болон төрийн оролцоотой 106 аж ахуйн нэгжийн 2021 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн үр дүнг тооцохдоо олон улсын байгууллагууд компанийн ерөнхий үзүүлэлтийг тодорхойлохдоо баримталдаг зарчим болох хөрөнгийн өгөөж, эздийн өмчийн өгөөжийн үзүүлэлтийг тооцон гаргасан. Цаашид төрийн өмчит хуулийн этгээдүүдэд энэ туршлагыг нэвтрүүлэх бөгөөд ТӨБЗГ-аас баталсан холбогдох журмын шалгуур үзүүлэлтэд хөрөнгө өгөөжийг сайжруулсан байдал, эздийн өмчийн зохистой харьцааг харгалзах үзүүлэлтүүдийг тусгаж өгсөн. **Хэрэгжилт 70.0%.**

Гурав. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Хэрэгжилтийг тайлагнахдаа 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтот түвшин, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан тайлагнах (шаардлагатай тохиолдолд дэлгэрэнгүй тайланг файлаар хавсаргах);
- Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн санхүүгийн эх үүсвэрийг гүйцэтгэлийн хамт тодорхой тайлагнах;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг тайлант хугацаагаар **хүрсэн түвшинг** тодорхойлж байх;

Шийдвэрлүүлэх асуудал /Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын түвшинд/

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний:

4.1.4.1. Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбох арга хэмжээ нь ТӨБЗГазарт хамаарах заалт биш учраас Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn–нээс хасалт хийлгүүлэх саналтай байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА **Б.ЦЭНГЭЛ**

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА **Н.ГАНБОЛД**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН **Д.ЦЭРЭНЛХАМ**